



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/84

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "г" дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэр Жирмийн зүүнд байршилтай Борын Төмөртогтох (ЗЮ64010872)-ийн өвөлжөөний зориулалттай 700 м.кв (0.07 га) газрыг Сугирын Энхтайван (ЗК87020319)-д зориулалтын дагуу шилжүүлэн 13 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Л.Хулан)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/144 дүгээр захирамжийн 76 дахь хэсэг мөн газар эзэмших эрхийн 000025235 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

